

“ҮНЭТ ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙН ЗЭРЭГЛЭЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ” ҮЗМЭРИЙН ЖАГСААЛТЫН ТӨСӨЛ

МОНГОЛЫН ТЕАТРЫН МУЗЕЙ

Д/д	Үзмэрийн нэр	Хувийн дугаар	Тоо ширхэг	Хэмжээ	УБМС-ийн дугаар РСН (прораммын)	Судлагдсан сурталчлагдсан байдал	Саналын үндэслэл	СӨҮТ-ийн санал
1	Ө.Лувсан хуурч	90-2310	1	Өндөр-83.5 см Өргөн-68.5 см Жаазтай: Өндөр-98.5 см Өргөн-84.2 см	1119МТМ01869	-“Зууны мэдээ” сонин -Х.Хайнзан "Бөмбөгөр ногооноос" 2001 он -“Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис” ном (2014 он) -ын 1-р ботийн 302-р нүүрт хэвлэгдсэн.	Оросын нэрт зураач К.И.Померанцев нь 1926-1939 онуудад Монгол улсад ажиллаж, амьдарч байх хугацаандаа тухайн үеийн Монгол орны нийгэм, аж байдал, ахуй амьдралын тухай харуулсан олон арван уран зураг, усан будаг, харандаан таталбар зургууд зурсан байдгийн нэг нь ард түмний дунд домог болон үлдсэн Ө.Лувсан хуурчийн хөрөг зураг юм. Энэ бүтээл музейд хадгалагдаж буй үзмэрүүдээс хамгийн хуучны, түүхэн бодит уран зурагт зүй ёсоор орно.	Дэмжсэн
2	Луун толгойтой хар хуур	95-04	1	Өндөр-124.5 см Цар: Өргөн-28 см Жин: 1905 гр Татлага: Урт-89 см Жин: 85 гр	1119МТМ00001	-“Зууны мэдээ” сонины 2017.09.22-ны №189 -“Өдрийн шуудан” сонины 2012.10.04-ний №203 -“Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис” ном (2014 он) -ын 1-р ботийн 278-р нүүрт хэвлэгдсэн. -Монголын Театрын музей байгуулагдсаны 25 жилийн ойд зориулан гаргасан “Ардын хөгжим” үзэсгэлэнгийн каталоги (2016 он) -д хэвлэгдсэн.	Монголчуудын эртнээс хэрэглэж ирсэн хөгжмийн зэмсгийн нэгэн төрөл болох уг хуур нь шанаган хэлбэртэй, эртний Монголын хуурын шинж чанарыг агуулсан, чавхдаст хөгжмийн зэмсгийн харьцааг зөв гаргасан биет бус соёлын өвийн төлөөллийн нэг билээ. Архангай аймгийн Эрдэнэмандал сумын харъяат Д.Вандан /1903-1963 он/ аав Дандараас өвлөн авч, Вандан ууган хүү Базаррагчаадаа өвлүүлсэн. Соёлын биет ба биет бус өвийг өвлөн уламжлагч Базаррагчаагийн авъяас чадварыг үнэлж 1975 онд Монгол	Дэмжсэн

							улсын “Тэргүүний уран сайханч” цолоор шагнажээ.	
3	Урлагийн ажилчдын уулзалт	94-496	1	Өндөр-186 см Өргөн- 258 см Жаазтай: Өндөр-191 см Өргөн- 264.5 см	1119MTM00004	“Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис” ном (2014 он) -ын 1-р ботийн 303-р нүүрт хэвлэгдсэн.	Бодит үйл явдлаас сэдэвлэн зурсан. 1943 онд Сайд нарын зөвлөлийн Ерөнхий сайд Маршал Х.Чойбалсан Улаанбаатар хотын театр, цирк, кино, клубүүдийн уран бүтээлчдийг хүлээн авч уулзан, соёл урлагийн тухайн үеийн хөгжил болон цаашид юу хийх талаар ярилцаж, шийдвэр гаргажээ. Энэ уулзалтад оролцсон хүмүүсийг Ардын зураач Г.Одон зохиомжлон үзэсгэлэнд зориулан зурсан гэж музейн эрдэм шилжилгээний ахмад ажилтан Х.Хайнзан гар бичмэлдээ бичсэн байдаг. Уг уран зураг нь музейн ховор үзмэрийн нэг билээ.	Дэмжсэн
4	ДЗО-II их наадам	94-516	1	Өндөр-140 см Өргөн-200 см Жаазтай: Өндөр-157 см Өргөн- 216 см	1119MTM00020	-“Зууны мэдээ” сонины 2017.11.24-ний №235 -“Монголын музейн шилдэг үзмэрийн дээжис” ном (2014 он) -ын 1-р ботийн 303-р нүүрт хэвлэгдсэн.	Ардын зураач Н.Цүлтэм судалгааны үндсэн дээр 1952 онд зурсан “Дэлхийн Залуучууд Оюутны Их наадам” уран зураг нь музейн гадаад, дотоод үзэгчдийн сонирхлыг татсан үзмэрүүдийн нэг билээ. Уг уран зурагт 1949 онд Унгар улсын нийслэл Будапешт хотод болсон Дэлхийн залуучууд оюутны 2-р их наадамд оролцохоор ирсэн Монголын болон бусад олон үндэстнийг дүрслэн зурсан. Уг наадамд 70-аад орны уран бүтээлчид оролцсоноос Монгол улс 42 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон байдаг.	Дэмжсэн
НИЙТ 4 ДЭСИЙН 4 ҮЗМЭР								